

**ГАДААД АЛБАНЫ АЖИЛТАН БЭЛТГЭХ АНХНЫ ТӨРИЙН СУРГУУЛЬ -
МУИС-ИЙН ОУХС-ИЙГ ҮҮСГЭН ХӨГЖҮҮЛЭХЭД
М. ДҮГЭРСҮРЭНГИЙН ГАРГАСАН ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ,
ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР**

*Н. Алтанцэцэг**

Улс орны хөгжлийн чухал хүчин зүйлүүдийн нэг бол хүний нөөц, мэргэжилтэй боловсон хүчин, түүний чадавхийн асуудал юм. Даяаршлын эрин үе бидэнд дэлхийн олон улс оронтой харилцаа холбоо, хамтын ажиллагаагаа хөгжүүлж улс орноо авч явах ихээхэн хариуцлагатай үүрэг хүлээлгэсэн. Энэ нөхцөл байдалд олон улсын харилцааны мэргэжилтэн дотооддоо бэлтгэх шаардлага урган гарсан юм. Урьд өмнө Монгол улсад бэлтгэж байгаагүй нарийн мэргэжлийн боловсон хүчин их, дээд сургуулийн түвшинд бэлтгэх шийдвэр гаргахад нэлээд зоримог алхам, ихээхэн хөөцөлдлөг байсан нь эргэлзээгүй. Монгол улсад МУИС-ийн дэргэд Олон улсын харилцааны дээд сургууль байгуулах шийдвэр Гадаад Хэргийн Яам, Үндэсний Хөгжлийн Яам, Худалдаа Үйлдвэрийн Яамны дэмжлэгтэйгээр 1991 оны 12-р сард гарсан байдаг.

Сургалтын орчин бүрдүүлэх, багшлах боловсон хүчин, ном сурах бичиг бий болгох, сургалтын стандарт, хөтөлбөр боловсруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх явдал амаргүй байсан. Тухайн үед гадаад албаны мэргэжилтэнг Монгол улсад бэлтгэх явдлыг тууштай дэмжин, түүнийхээ төлөө насан эцэслэтлээ хүчин зүтгэсэн хүний нэг бол манай гарамгай дипломатч, Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд М. Дүгэрсүрэн байсан юм. ОУХС-ийн үүсэл хөгжил түүний зүтгэл, санаачлага, хөдөлмөртэй салшгүй холбоотой явж ирсэн гэдгийг энэхүү ойн арга хэмжээнд дурсан тэмдэглэхэд таатай байна.

МУИС-ийн ОУХС-ийн анхны захирал профессор Ж.Баясах дурсахдаа: "Миний бие ОУХС-ийг байгуулж 1991-1999 онд захирлаар ажиллаж байхдаа М.Дүгэрсүрэн гуайтай хамтран ажиллаж, сургуулийг хөл дээр нь босгосон билээ. М.Дүгэрсүрэн гуай зөвлөхөөр ажиллаж байхдаа тус сургуулийн сургалтын хөтөлбөрийг зохиоход гар бие оролцсон

* МУИС, ОУХС-ийн захирал, профессор, доктор

бөгөөд Москвагийн ОУХДС, Москвагийн Дипломат Академи, Хятадын ОУХС, Японы Дипломат Академи, Оксфордын Их сургуулийн ОУХС гэх мэт сургуулиудын хөтөлбөрүүдийг дипломат төлөөлөгчдийн газраар дамжуулан авч сургалтын төлөвлөгөөг зохиолцсон юм. Мөн тухайн үед ГХЯ-ны сайд байсан Ц.Гомбосүрэн гуайтай удаа дараа уулзаж, яамны туслалцаа дэмжлэг авч байсан бөгөөд сайдын тушаалаар ГХЯ-ны бүх дипломатууд ОУХС-д 20 цагийн хичээл заалгах шийдвэр гаргуулж, дипломатуудыг сургалтанд хамруулж байсан юм” гэж өгүүлсэн.

М.Дүгэрсүрэн ОУХС-ийг үүсгэн байгуулагчдын нэг

Сургалтын үүрэг, зорилго, агуулга, бүтцийн талаар

Дүгэрсүрэн гуай дөч гаруй жил дипломат албыг хашихдаа Монголын боловсон хүчний асуудалд ихээхэн анхаарал тавьж, олон улсын харилцааны мэргэжилтэн дотооддоо бэлтгэх, сургах, боловсруулахыг чухалд үзэж байсан. МУИС-ийн дэргэд ОУХС сургууль байгуулагдах явдлыг туйлын талархан хүлээн авч, энэ сургуулийг үүсгэн байгуулахын төлөө өөрийн мэдлэг чадвар, сэтгэл санаагаа зориулан, дэмжин, туслах явдлыг эрхэмлэж ирснээр зогсохгүй, гар бие оролцон байгуулалцаж ирсэн билээ.

ОУХС хэрхэн байгуулах талаар 1991 оны 12 сарын 1-ний өдөр “Монгол улсын Их Сургуулийн дэргэд Гадаад харилцааны дээд сургууль байгуулагдаж байгаатай холбогдсон зарим санал”¹ (бичгийн машинаар цохиж бичсэн 5 хуудас) бичиж өгсөн байдаг. Түүндээ тухайн үеийн олон улсын хөдөлмөрийн хуваарьт Монгол улс өргөнөөр оролцох болсон явдлыг дэлхийн шинэ төлөв байдалтай уялдуулан авч үзэж, “энэ нөхцөл байдал нь манай улсын гадаад бодлого, харилцааны үйл ажиллагааны шинэ чиг баримтлал, өвөрмөц практик арга барилыг улам бататган идэвхжүүлэх шаардлагыг эрс тавьж байна” гээд “манай гадаад харилцааны боловсон хүчнийг өөрийн хүчээр, өөрийн байдалд тохирсон чиглэл, зорилготойгоор бэлтгэх биетэй ажлыг яаралтай эхлэх нь практик зорилт болж байна” гэж үзсэн байдаг. Уг саналдаа Сургууль байгуулах зорилго, шаардлага, Сургуулийн үүрэг зорилго, Сургалтын үндсэн агуулга, Сургуулийн үйл ажиллагааны хүрээ, арга барилын асуудлууд, Сургуулийн зохион байгуулалт, бүтцийн талаар тодорхой зөвлөмж, саналуудыг дэвшүүлэн тавьсан байна.

¹ М.Дүгэрсүрэн. Монгол Улсын Их Сургуулийн дэргэд Гадаад Харилцааны Дээд Сургууль байгуулагдаж байгаатай холбогдсон зарим санал, 1991-12-1 (Сургуулийн баримт бичгийн эмхэтгэл № 05)

Арван зургаан жилийн өмнө М.Дүгэрсүрэн сайдын хүсэж мөрөөдөж байсан Сургуулийн зорилт, бүтэц, зохион байгуулалт, сургалтын хөтөлбөр, сургалтын орчинг одоогийн амьдрал дээр хэрэгжиж байгаа сургуулийн үйл ажиллагаатай харьцуулан үзэхэд товчхон үгээр дүгнэвэл үндсэнд нь биелсэн байна гэж хэлж болно.

Гадаад харилцааны мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхдээ бакалаврын сургалтаас гадна бусад орны их, дээд сургуулиудын жишгээр магистр, докторын сургалт явуулахыг чухалд үзэж санал болгосон байдаг. “Монголын нөхцөлд олон улсын харилцааны мэргэжилтэнг орчин үеийн шаардлагын түвшинд бэлтгэн гаргахад мэргэжлийн боловсрол, сургалтыг зохих түвшинд явуулах, магистр, докторын түвшингийн сургалт явуулах нь зүйтэй юм” гэж үзэж санал болгосон байдаг. Бид МУИС-ийн хүрээнд бакалавр 4 жил, магистр 1,5-2 жил, доктор өдөр, эчнээ, экстернат хэлбэрээр бэлтгэн гаргадаг болсон. Бүх гурван шатны сургалтын хөтөлбөрийг олон улсын ижил төстэй сургуулиудын хөтөлбөрийн хэмжээнд боловсруулж, хэрэгжүүлж байгаа. Сургалтын стандартыг БСШУЯ, МУИС-ийн дүрэм, журам, шаардлагын дагуу боловсруулдаг.

Бакалаврын түвшинд нийт 128 кредитийн хичээл ордгоос 25-27 кредит нь их сургуульд заавал үзэх ерөнхий эрдмийн хичээл, 80 орчим кредит нь олон улсын харилцааны мэргэжлийн заавал үзэх хичээл, 23-25 кредит нь сонгон суралцах хичээлүүд байгаа. Одоо орж байгаа мэргэжлийн хичээлүүд тухайн үед Дүгэрсүрэн сайдын санал болгож байсан хичээлүүдийг бүрэн хамруулж гүнгийрүүлэн, баяжигдаж сургалтын хөтөлбөрт тусгагдан хэрэгжиж байна.

Мэргэжлийн хичээлүүдээс гадна гадаад хэлний сургалтанд, тухайлбал, “англи, орос, хятад, тусгайлсан орны хэл заах”²-ыг зөвлөсөн байдаг. Манай сургуулийн хичээлийн 42 кредитийг гадаад хэл эзэлдэг ба бакалаврын түвшинд 1-4 ангийг төгсгөл англи хэлийг 28 кредит, 2-4 ангийг төгсгөл орос, хятад, япон, солонгос, герман, франц хэлийг 14 кредит үзэхээр хичээлийн хөтөлбөрт тусгасан байгаа. Магистр, докторын хичээлүүд ч мөн Их сургуульд мөрдөгддөг стандартын дагуу явагддаг.

Мөн сургуулийн дэргэд Эрдмийн Зөвлөлтэй байхыг санал болгож “Эрдмийн Зөвлөл нь сургалтын ажлыг удирдахын хамт шинжилгээ судалгааны ажлыг эрхлэн хариуцах бөгөөд профессор, багш нар, тэнхмүүдийн төлөөлөгчдөөс бүрэлдсэн байх нь зүйтэй бизээ”³ гэсэн байдаг. Одоогийн байдлаар ОУХС-д байнгын Эрдмийн Зөвлөлөөс гадна олон улсын харилцаа, гадаад бодлогын чиглэлээр магистр, докторын зэрэг хамгаалуулах Эрдмийн

² Мөн тэнд, тал 3

³ Мөн тэнд, тал 5

Зөвлөл ажиллаж байна. Магистрын зэрэг хамгаалуулах Эрдмийн Зөвлөлийг 1999 онд, олон улсын харилцаагаар Боловсролын докторын зэрэг хамгаалуулах Эрдмийн Зөвлөлийг ОУХС-ийн дэргэд Монгол улсад анх удаа 2003 онд байгуулсан.

Гадаад харилцаа, олон улсын асуудлаар үндэсний болон олон улсын бага хурал, семинар, симпозиум зохиохыг зөвлөсөн байдаг. ОУХС олон улсын харилцааны чиглэлээр олон улсын, улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, симпозиум тогтмол зохион байгуулдаг болсон. Түүнээс гадна оюутны, магистрантын, докторантын түвшинд эрдэм шинжилгээний хурал, судалгааны семинар түвшин бүр дээр жилд 1-2 удаа тогтмол явуулдаг уламжлалтай болсон.

Мөн сургуулийн эрдэм шинжилгээний хэвлэлтэй болохыг зөвлөж байсан. ОУХС 1991 оноос “Алтан аргамж” нэртэй, 2002 оноос “Олон улсын харилцаа” нэртэй эрдэм шинжилгээний сэтгүүлийг жилд тогтмол хоёр удаа гаргадаг болоод байна. Дүгэрсүрэн гуай сургалтын орчинг сайжруулах, номын сантай болох зэрэг тал дээр санаа тавьж, ОУХС Азийн сантай хамтарсан төсөл боловсруулж номын сантай болохыг зөвлөсөн байдаг.⁴

ОУХС 2005 оны 12 сард 1 тэрбум 800 сая орчим төгрөгийн өртөгтэй өөрийн гэсэн орчин үеийн байртай болсон. Одоогийн байдлаар Хятадын засгийн газраас бэлэглэсэн 30 сая төгрөгийн өртөгтэй хэлний лингафон кабинет (2002 онд), 20 компьютер суурилуулсан компьютерийн лаборатори, мэргэжлийн номын сангууд - Азийн фондоос 1000 гаруй ном, 1500 номтой Австрийн номын сан, 1000 номтой Солонгосын номын сан оюутнуудад үйлчилж байна. Манай сургуулийн байранд байрладаг Америкийн Монгол судлалын төвтэй хамтран 2007 оны 3 сард интернет номын сангийн сүлжээ оруулж ирсэн нь зөвхөн ОУХС төдийгүй монголчууд америктай хамтарсан орчин үеийн номын сангаар үйлчлүүлэх бүрэн боломжтой болоод байна.

М. Дүгэрсүрэн МУИС-ийн ОУХС-ийн гадаад харилцааны суурийг тавигч

Ижил төрлийн сургуулиудтай холбож, харилцаа тогтооход гүйцэтгэсэн үүрэг

Профессор Ж.Баясах тухайн үед ОУХС байгуулагдахад М.Дүгэрсүрэн агсан уг сургуулийг гадаадын сургуулиудтай холбож өгснийг цохон тэмдэглэхдээ “гадаадын ижил төстэй сургуультай шууд харилцаа тогтооход гар биечлэн оролцож 1991 оноос хойш

⁴Amb. Mangalyn Dugersuren. Consultant, NUM/SFS, Yadmaagyn Ganbaatar, Deputy Head, Oriental Studies Department, NUM/SFS – Report on Study tour, 25 July 1993, Ulaanbaatar.p., 6

дэлхийн Дипломат Академи, ОУХС-иудын Захирлуудын Зөвлөлгөөнд байнга оролцох болсон бөгөөд энэ нь цаашид сургуулийг боловсронгуй болгоход гадны сургуулиудаас санаа авах, багш эрдэмтэдтэй холбоо тогтоох, лекц уншуулах ажлын эхлэл болсон юм” гэж тэмдэглэсэн байдаг. Одоо ч бид Дэлхийн Дипломат Академи, ОУХС-иудын Захирлуудын Зөвлөлгөөнд жил бүр оролцож байгаа ба энэ нь сургуулийн сургалтын стандартыг олон улсын түвшинтэй холбон, нягт хамтран ажиллахад чухал үүрэг гүйцэтгэсээр байна. ОУХС энэ хүрээнд нийт таван тивийн 70 гаруй Дипломат Академи, ОУХС-тай хамтын ажиллагаатай байна.

М.Дүгэрсүрэн гуай 1993 оны 6-7 сард тухайн үеийн ОУХС-ийн Дорно дахин судлалын тэнхмийн эрхлэгч Ядмаагийн Ганбаатарын хамт Хятад, Япон, Солонгосын ижил төстэй сургуулиудад очиж биечлэн танилцаж, өөрийн орны ОУХС-г танилцуулж, туршлага судалж, холбож өгөх ажлыг өөрийн биеэр гүйцэтгэж байсан нь үнэхээр энэ сургуулийн төлөө хүчин зүтгэж байсны тод жишээ юм. М.Дүгэрсүрэн гуайн 1993 оны 7 сарын 25–д бичиж өгсөн “Судалгааны айлчлалын тайлан”⁵ –д (6 бичгийн машинаар бичсэн тайлан) “1993 оны 6 сарын 23-наас 7 сарын 4 хүртэлх хугацаанд БНХАУ, Япон, БНСУ-ын Гадаад харилцааны сургуулиудын бүтэц, зохион байгуулалт, боловсрол, сургалт, судалгааны үйл ажиллагаатай танилцах зорилгоор МУИС-ийн ОУХС-ийн судалгааны баг явсан юм. Энэ аяллыг АНУ-ын Азийн Сан санхүүжүүлж, дэмжлэг үзүүлсэн. Токио, Сөүл дэх Азийн Сангийн төлөөлөгчид очсон газар дэмжлэг үзүүлж тусалж байлаа” гэж тэмдэглэсэн байна.

БНХАУ-д Бээжингийн Гадаад Харилцааны Сургууль /Foreign Affairs College/ дээр очиж 1993 оны 6 сарын 23-нд холбоо тогтоож, сургуулиа танилцуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, тухайн сургуулийн үйл ажиллагаатай танилцсан байдаг. Бээжингийн ГХС өөрийн сургуулийн сэтгүүл, ном, хэвлэл, судалгааны материал, сургалт судалгааныхаа үйл ажиллагаатай танилцуулсан байна. Уг сургуулиас эрхлэн гаргадаг “Foreign Affairs Journal”-г манай сургуульд илгээж байхыг хүссэнийг ёсоор болгож одоог хүртэл манай сургууль авч байгаа нь Хятадын гадаад бодлого, олон улсын талаарх үзэл баримтлалыг судалж мэдэхэд ач холбогдлоо өгсөөр байна. Тухайн үед Монгол улсаас БНХАУ-д сууж байсан Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд Х.Олзвой сургуулийн үдийн зоогонд уригдан ирж хоёр сургуулийн хооронд оюутан солилцох тухай сургуулийн захирал Элчин сайд Лю Шанд санал болгож байсан байна. Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Х.Олзвой 1995-2002 онд манай сургуульд багшилж байсан бөгөөд МУИС-ийн ОУХС-

⁵ Amb. Mangalyn Dugersuren. Consultant, NUM/SFS, Yadmaagyn Ganbaatar, Deputy Head, Oriental Studies Department, NUM/SFS – Report on Study tour, 25 July 1993, Ulaanbaatar

ийн Олон улсын эдийн засгийн харилцааны анхны тэнхмийн эрхлэгчээр ажиллаж байгаад насан өөд болсон юм.

Дүгэрсүрэн гуай мөн **Бээжингийн Их Сургуулийн Ази-Африк судлалын Институт** (Institute of Afro-Asian Studies, Peking University), **Шанхайн Олон Улс судлалын Институтын** (Shanghai Institute for International Studies) удирдлага, профессоруудтай уулзаж, тэдний сургалт, судалгааны ажилтай танилцаж, ОУХС-ийг танилцуулж явсан байна. Чингэхдээ Нью-Йорк хотноо танилцсан өөрийн хуучин танил, Шанхайн Олон улс судлалын институтын хүндэт Ерөнхийлөгч Лян Юфантай уулзаж хоёр сургуулийн хамтын ажиллагааны талаар халуун дотно санал солилцсон байдаг.

Дүгэрсүрэн гуай 1993 оны 6 сарын 28-нд **Япон дахь Нэгдсэн Үндэсний Их сургуулийн** (United Nations University) Хөгжил төлөвлөлтийн тэнхмийн захирал, профессор Таркиско Делла Сентатай уулзаж МУИС-ийн ОУХС өөрийн сургалт, судалгаандаа НҮБ-ын үүрэг роль, үйл ажиллагааг хичээлийн хөтөлбөрт оруулж, сургаж, судалж байх, мөн НҮБ-ын албан бичиг баримт, судалгааны материалыг сургалт судалгааны гол эх сурвалж болгон ашиглаж байхын ач холбогдлыг цохон тэмдэглэж санал солилцсон байдаг. Тус сургуулиас НҮБ болон Сургуулиас гаргасан ном хэвлэл, материалыг ОУХС-д явуулж байх хүсэлт тавьсан байна.

Өнөөгийн байдлаар ОУХС Женевт байрладаг НҮБ-ын Сургалт, судалгааны институттай холбоотой ажилладаг. Уг институтаас гаргаж байгаа материал авч “он-лайн” сургалтанд боломжийн хэрээр хамрагдаж байна. Жишээлбэл, энэ оны 2 сард манай сургуулийн багш Д.Оюунсүрэн НҮБ-ын Сургалт, судалгааны институтээс зохион явуулсан “он-лайн” сургалтанд хамрагдаж амжилттай төгсч, диплом авсан нь бахархууштай хэрэг болсон юм. Энэ мэтийн сургалтанд манай залуу дипломатуудыг хамруулах талаар ГХЯ анхаарах нь зүйтэй болов уу.

Японд байх хугацаандаа **Японы Гадаад Хэргийн Яамны дэргэдэх Гадаад албаны сургалтын институт** (Foreign Service Training Institute, Ministry of Foreign Affairs)-д зочилж, сургуулиа танилцуулж, хоёр сургуулийн хамтын ажиллагааны талаар санал солилцсон байна. Энэ үеэр сургуулийн захирал хоёр сургууль хамтарч ажиллах боломжийг хайя гэж хэлсэн байгаа юм. Энэ сургууль үндсэндээ хаалттай. Японы гадаадад томилолтоор ажиллах хүмүүст албан тушаалын зэрэглэл, гүйцэтгэх ажил үүргийнх нь хүрээнд тэр бүү хэл дагалдан яваа гэр бүлийн хүмүүст хүртэл богино хугацааны сургалт явуулдаг сургууль

юм. Энэ сургуулийн хөтөлбөр, программтай бид танилцсан. Ийм сургалтыг бид Монгол улсад зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Олон улсын хөгжлийн Ахисан шатны сургалын сангийн (Foundation for Advanced Studies in International Development) Гүйцэтгэх захирал Элчин сайд Шинэсүке Хирайтай 6 сарын 29-нд уулзаж, тэр Сангийн үүрэг рольтой танилцаж, хөгжиж буй орнуудын хүмүүст хөгжлийн талаарх сургалт явуулдаг, тэдэнтэй хамтран ажиллах, дэмжих, мөн Японы эдийн засаг, техникийн тусламжийн талаарх мэдлэг олгох зэрэг Монголын ач холбогдолтой танилцаж, Монголын Хөгжлийн агентлаг хамтарч ажиллах шаардлагатай юм гэж цохон тэмдэглэж ярилцсан байна. 30-ны өдөр **Токиогийн Их сургуулийн Хуулийн Факультет** (Faculty of Law, University of Tokyo) дээр очиж, сургуулийн сургалт, үйл ажиллагаатай танилцсан байдаг. Чингэхдээ олон улсын эрх зүйн сургалтын талаар сонирхсон байдаг.

БНСУ-ын ижил төстэй сургуулиудын үйл ажиллагаатай мөн танилцсан байдаг. 1993 оны 7 сарын 1-нд **Ёнсей Их сургуулийн Өрнө, Дорно судлалын Институт** (Institute of East and West Studies, Yonsei University) дээр очиж, бүс нутаг судлалын сургалт, түүний арга зүйтэй танилцсан байна. Мөн Ёнсей Их сургууль, МУИС-ийн хооронд хамтын ажиллагааг хөгжүүлэх саналыг цаад тал талархан хүлээж, дэмжсэн байдаг.

Сөүлийн Үндэсний Их сургуулийн Нийгмийн Ухааны коллежийн Олон улс судлалын төв (Center for International Studies, College of Social Sciences, Seoul National University) дээр очиж үйл ажиллагаатай нь танилцсан байна. Уг төвийн удирдлага Солонгосын гадаад албаны мэргэжилтэн, дипломатуудыг бэлтгэхэд гарамгай үүрэг гүйцэтгэдэг гэдгээ цохон тэмдэглээд сургалтанд олон улсын эрх зүй, дипломат үйл ажиллагаа, олон улсын харилцааны түүх зэрэг мэргэжлийн хичээлүүдийг оруулдаг хийгээд Ази, Зүйн хойд Ази, Солонгосын асуудлаар олон улсын хурал зөвлөлгөөн, семинар тогтмол явуулж сургалт, судалгааг хослуулдаг тухайгаа танилцуулсан байна.

БНСУ-ын **Гадаад Хэргийн Яамны дэргэдэх боловсрол, сургалтын Гадаад Харилцаа Үндэсний Аюулгүй байдлын Институт** (Institute of Foreign Affairs and National Security, Ministry of Foreign Affairs) дээр очиж сургуулийн тухай танилцуулж, хойшид хамтран ажиллах боломжийн тухай санал болгосон байна. Уг Институт 1963 онд байгуулагдсан байна. Институтын удирдлага сургуулийн сурах орчин, номын сантай танилцуулж, уг сургуулийг байгуулах, орчинг бүрдүүлэхэд Азийн Сан их үүрэг гүйцэтгэсэн гэж дурьдсан байна. Энэ Институт бас хаалттай.

Ханкугийн Их Сургуулийн Гадаад судлалын Солонгосын бүс нутаг судлалын институт (Institute for Korean Regional Studies, Hankuk University of Foreign Studies)-тэй уулзахад сургуулийн орлогч проф. Баон Ман Ах, магистр, докторын сургалтын декан нар сургуулийн гадаад харилцаа, судалгааны сургалт явуулдгийг онцлон танилцуулсан байна. Ханкугийн Их сургууль, МУИС-тай харилцаа тогтоох бүрэн боломжтойг уулзалтын явцад чухалчлан тэмдэглэсэн байдаг. Энэ айлчлалын үеэр БНСУ-д сууж байсан Онц Бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Үржинлхүндэвтэй Дүгэрсүрэн сайд уулзаж зорилгоо танилцуулсан байдаг. Дашрамд дурьдахад Үржинлхүндэв сайд Монгол, Солонгосын сургуулиудын хооронд холбоо тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн, ОУХС, Солонгосын сургуулиуд Инха, Сангингуан зэрэг сургуулиудын хамтын ажиллагааг дэмжиж ирснийг дурьдахад таатай байна. Мөн ГХЯ-ны Дэд сайд асан А.Баттөр ОУХС-г Солонгосын Сангингуан сургуультай 2004 онд холбоо тогтоож, манай сургуульд 1000 гаруй ном бүхий номын сан байгуулж, багш, оюутан солилцох зэрэг цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд гар бие оролцож байсныг баяртайгаар цохон тэмдэглэе.

М.Дүгэрсүрэн сайд Монгол улсын гадаад орчин аятай бүрдэж эхэлсний ердөө гуравхан жилийн дараа 1993 онд МУИС-ийн ОУХС-ийг бүс нутгийн Хятад, Япон, Солонгосын ижил төстэй арав гаруй сургуулиудтай холбох, тэднээс суралцах, хамтын ажиллагаа хөгжүүлэх ажлын эхлэлийг тавьж, манай сургуулийн гадаад харилцааны үндэс суурийг тавьж өгсөн юм.

М.Дүгэрсүрэн Олон улсын харилцааны мэргэжлийн анхны сурах бичгүүдийн зохиогч, эрдэмтэн

Урьд өмнө Монгол улсын түүхэнд байгаагүй Олон улсын харилцааны мэргэжилтэн бэлтгэх сургууль байгуулан сургалт явуулахад юуны түрүүнд мэргэжлийн ном, сурах бичигтэй болох явдал тулгамдан гарч ирсэн нь дамжиггүй. Түүний дотор олон улсын харилцааны торгон мэргэжил болох дипломат үйл ажиллагаа, түүний арга ухаан, гадаад бодлогыг хэрэгжүүлэх механизм, түүний практик үйл ажиллагааг ойлгуулах, түүний талаар системтэй, нухацтай мэдлэг олгох явдлыг Дүгэрсүрэн сайд чухалчлан үзэж, ОУХС-ийн нэн тэргүүний зорилтуудын нэг болгон тавьсан байдаг. Энэ амаргүй, дипломатын мэдлэг, нөр их хөдөлмөр, цаг хугацаа, эрдэм шаардсан ажилд М.Дүгэрсүрэн өөрийн биеэ зориулж ирсэн. Өөрийн мэргэжил нэгт Монгол улсын гарамгай дипломатч О.Хосбаяр гуайн хамт

олон улсын харилцааны анхны сурах бичгүүдийг бичих үйл хэрэгт эрдэм мэдлэг, сэтгэл оюунаа зориулсан юм. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр нар ОУХС-ийн захиалгаар “Дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс” хэмээх алдарт номыг 1998 онд хэвлүүлэн гаргасан байдаг. Уг номондоо: “Бид олон улсын харилцаа, дипломат ажиллагааны талаар сурч судлагчдад үндсэн мэдлэгтэй болоход нь тус болохыг голлон зорив. Бас олон улсын харилцаанд хамааралтай аливаа ажил төрөл эрхэлдэг хүмүүс гадаад бодлого, дипломат ажиллагааны арга ухаан, практик ажлын зохих мэдлэгтэй байх хэрэгцээ улам нэмэгдэж байгааг бодолцон бичихийг хичээв”⁶ гэсэн нь гадаад харилцаанд оролцож байгаа хэнбугай нь ч энэ талаарх мэдлэгтэй байх шаардлагатай юм шүү гэсэн чухал сургамж өгч энэхүү номоо зориулан бичсэн байдаг. Зохиогчид “тус улсын гадаад харилцааны янз бүрийн салбарт ажилладаг хүмүүс, ер нь улс төрийн зүтгэлтэн, төрийн албан хаагч, түүнчлэн бизнес эрхлэгчдийн олон улсын үйл ажиллагаанд нь өчүүхэн боловч тус нэмэр болохыг бид хичээсэн. Чухам ийм учраас энэ номыг зөвхөн сургалтын хэрэглүүр төдийгүй бас зарим хэсгийг нь практик ажиллагаанд хэрэглэх лавлагааны чанартай болгохыг оролдов. Дипломат ажиллагаа явуулах хүний эзэмшвэл зохих дадал, зан чанарын талаар товч боловч бичиж толилуулахыг хичээсэн”⁷ гэсэн нь зохиогчид Монгол улсын дипломат ажил явуулж буй хүн бүрийн мэдлэг, мэргэжил, дипломат хүний ёс суртахуун, зан чанарт нэлээд анхаарал тавьж өөрсдийн ажлын туршлага, мэдлэгээс сургахыг хичээсэн нь өнөө үед улам ач холбогдолтой болж байна.

М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр нар 1996 онд анхны хэвлэл, 1999 онд хоёр дахь хэвлэл болгон “Олон улсын эрх зүй”⁸ номыг, мөн Олон улсын харилцааны дээд сургуулийн (тэр үеийн нэрээр) захиалгаар бичсэн байдаг. Анхны хэвлэлийн редакцийг манай нэрт дипломатч Ж.Энхсайхан, хоёр дахь хэвлэлийн редакцийг Г.Амар нар хийсэн байна. Уг ном нь олон улсын эрх зүй хэмээх дипломатын заавал эзэмших эрх зүйн төрлөөр бичсэн анхны монгол сурах бичиг юм. Зохиогчид сурах бичигтээ олон улсын эрх зүйн тухай ойлголт, түүний олон улсын харилцаанд гүйцэтгэх үүргийг түүх, орчин үеийн нөхцөл байдалтай холбон авч үзсэнээс гадна “Монгол улс олон улсын хамтын ажиллагаанд оролцох нь улам өргөжиж, манай хууль тогтоомж, гадаад харилцаанд олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээг дээдлэн сахих арга ажиллагаа улам өргөжиж” байгаад онцлон анхаарч номоо зориулсан байдаг. Энэ хоёр сурах бичгээр зөвхөн ОУХС ч биш манай улсын олон улсын

⁶ М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс, УБ., 1998, Оришил

⁷ Мөн тэнд

⁸ М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон Улсын Эрх Зүй, УБ., 1996, 1999

харилцаа заадаг бүх их дээд сургууль сургалт явуулж олон зуун оюутанд дипломат албаны мэргэжлийн мэдлэг олгож байгаа билээ.

М.Дүгэрсүрэн Монголын олон улсын харилцааны мэргэжилтэн Монголоо сайн мэддэг тэр тусмаа Монголын гадаад харилцааны түүх, гадаад бодлого, дипломат ажиллагааг ягштал мэддэг байх шаардлагатай гэж үздэг байсан. ОУХС байгуулахтай холбогдуулж 1991 онд бичсэн саналдаа “Монгол улсын тухай судалгаа, төр, улсын түүх, эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал төлөв, гадаад бодлого, харилцааны түүх, чиг баримтлал, практик зорилтууд, Монгол улсын аюулгүй байдлын стратегийн судалгаа, улсын зах зээлийн, эдийн засгийн хөгжил, төлөв, монгол хэл, утга захиолыг”⁹ сургалтын хөтөлбөрт оруулахыг санал болгосон байдаг.

Дүгэрсүрэн гуай санал болгоод заагаад байдаггүй хамгийн гол нь түүнийгээ хийдэг хүн байсан. Амьдарлынхаа эцсийн мөчид “Монгол улсын XX зууны гадаад бодлогын түүхэн тойм”¹⁰ номоо бичиж байгаад дуусгаж чадалгүй хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн. Энэ номыг МУИС-ийн ахисан шатны сургалтыг дэмжих “Азийн судалгааны төвийн” төсвийн хүрээнд хийж гүйцэтгэсэн. Тус номыг МУИС-ийн ОУХС-ийн зүгээс дуусгаж, гүйцээж бичиж өгөх саналыг хүлээн авч гүйцэтгэж өгсөн Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, ГХ-ийн сайд асан, манай сургуулийг анхнаас нь дэмжигч Ц.Гомбосүрэн гуайд энэ номыг гүйцээн бичиж өгсөнд талархал илэрхийлье.

Энэ ном XX зууны II хагаст Монгол улсын гадаад харилцааны салбарт ажиллаж байсан, Гадаад хэргийн сайдын албыг энэхүү түүхэн нөхцөлд хашиж байсан манай улсын нэрт дипломатуудын өөрийн нь гараар бичигдсэн учир зохиол гэхээсээ илүү Монгол улсын гадаад харилцааны хөгжлийн түүхэн эх сурвалж нь болж байгаагаараа илүү үнэ цэнэтэй ном болсон. Энэ номонд Дүгэрсүрэн сайдын бичсэн 2,3,4-р бүлгийг хөндөөгүй орхисон ба Гомбосүрэн сайд 1,5-р бүлгийг гүйцээн бичиж, Монгол улсын XX зууны гадаад харилцааны онцлог үйл явдлууд, Монгол улсын төр, засгийн тэргүүн, гадаад хэргийн сайд нар, дипломат харилцаатай улсууд, Монгол улс гишүүнээр элссэн олон улсын засгийнхуу газар хоорондын байгууллагууд зэргийг хавсаргаж өгсөн нь XX зууны Монгол улсын гадаад харилцааны мэдлэгийг гүнзгийрүүлэн ойлгоход ихээхэн тус нэмэр болсон юм. Дүгэрсүрэн сайд XX зууны Монголын гадаад бодлого, харилцааны үйл ажиллагааг бодит

⁹ М.Дүгэрсүрэн. Монгол Улсын Их Сургуулийн дэргэд Гадаад Харилцааны Дээд Сургууль байгуулагдаж байгаагаар холбогдсон зарим санал, 1991-12-1 (Сургуулийн баримт бичгийн эмхэтгэл № 05), тал 2,3

¹⁰ М.Дүгэрсүрэн, Ц.Гомбосүрэн. Монгол улсын XX зууны гадаад бодлогын түүхэн тойм, УБ., 2004

үнэнээр нь дэлхийд ойлгуулахыг ч бас хүсч байсан. Энэ нь түүний 2002 онд англи хэлнээ хэвлүүлсэн **“Mongolia in the world”**¹¹ номоор илэрхийлэгдэж байна.

М.Дүгэрсүрэнгийн дипломат алба хашиж байсан үедээ хурал, чуулган дээр хэлж байсан олон арван үг, нийтлүүлж байсан олон арван өгүүлэл, бичиж, орчуулж байсан олон номуудыг уншиж үзэхэд Монгол улсын дипломатын шинжлэх ухаанд дорвитой хувь нэмэр оруулсан эрдэмтэн байсан нь эргэлзээгүй. Хойшид бид энэ тал дээр анхаарлаа хандуулж судлах шаардлагатай байгаа юм.

М.Дүгэрсүрэн Монголын дипломатууд, гадаад албаны ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн чадавхийг ахиулахын төлөө санаа тавигч

Дүгэрсүрэн сайд Монголын дипломатуудын мэдлэг мэргэжил, зан үйл, ёс суртахуунд өндөр шаардлага тавьдаг байсныг үгүйсгэх хүн гарахгүй гэдэгт итгэлтэй байна. Монгол улсад олон улсын харилцааны мэргэжилтэнг дотооддоо орчин үеийн шаардлагын дагуу бэлтгэх үйл хэрэгт санаа тавихдаа нэгдүгээрт олон улсын харилцааны үндсэн мэдлэгийг Их сургуулийн хэмжээнд олгох, түүний хажуугаар мэргэжлийн дипломатууд, гадаад албаны аль ч салбарт ажиллаж буй хүмүүсийг мэргэшүүлэн сургах, давтан сургах хэрэгцээ байгаад байнга санаа тавьж ирсэн. МУИС-ийн ОУХС-ийн үйл ажиллагаа, явцыг ч ажиглан өөрийн саналаа удаа дараа дэвшүүлж байсан байдаг.

1994 оны 9 сарын 19-нд Гадаад харилцааны Яамны удирдлагад бичсэн “Гадаад албаны сургалт, судалгааны сургууль байгуулах тухай санал”-даа (хоёр хуудас хагас) “Гурван жилийн өмнө, 1991 онд МУҮИС-ийн дэргэд ОУХДС гэж нэг нэгжийг нээх үед, манай улсын гадаад харилцаа, дипломат албаны боловсон хүчнийг өөрийн хүчээр, үндэснийхээ нөхцөл байдал, шаардлагад тохирсон үзэл баримтлал, чиглэл зорилготойгоор бэлтгэж байх сургуулийг бүрэлдүүлэн байгуулах асуудлаар миний бие санал бичиж яамны удирдлагад толилуулж байсан билээ. ОУХДС-ийг дүр төрхөө олж, зүг чигээ тодорхойлоход нь туслах зорилгоор сүүлийн хоёр жил гаруй хугацаанд тэнд ажилласнаасаа үзэхэд уг сургуулийн одоогийн зохион байгуулалтыг өөрчилж, олон улсын судлалын ба гадаад албаны сургалтын сургуулиуд болгон хоёр хувааж, сүүлчийнхийг нь ГХЯ-ны харьяанд авах нь бүх талаасаа тохиромжтой бөгөөд олон улсын, ялангуяа Азийн орнуудын арга

¹¹ М.Дугэрсүрэн. *Mongolia in the world*, UB., 2002

туршлагатай нийцсэн оновчтой арга болох нь харагдлаа”¹² гээд ГХЯ-ны дэргэд богино хугацааны нэг жилийн сургалт явуулах сургалтын зорилго, үүрэг, агуулга, үйл ажиллагааны зохион байгуулалтын талаар бас санал боловсруулж өгч байсан байгаа юм. Энэ сургалтын онцлогийг “олон улсын харилцааны чухал үйл явдал, асуудлуудаар судалгааны ажил явуулж, гадаад бодлогын санал, зөвлөмж боловсруулж байх” гэж онцлон тэмдэглэсэн нь Дипломат Академийн хэмжээний сургалт явуулахыг ч хүсч зорьж байсан нь харагдаж байна.

1996 оны 6 сард “Гадаад хэргийн сургалт, судлалын үндэсний төвийн тухай” санал 7 хуудас материал боловсруулан бичиж ГХЯ-нд өгч байсан байх юм. Энэ бичигтээ “гадаад хэргийн болон дипломат ажлын боловсон хүчнийг өөрийн бололцоонд тулгуурлан үндэсний хэрэгцээ нөхцөл байдалд тохирсон үзэл баримтлал, чиг зорилготойгоор бэлтгэж байх асуудал хурцаар тавигдаж ирлээ. МУИС-ийн бүрэлдэхүүнд ОУХДС байгуулсан нь дээрх шаардлагыг хангах үзэл санаанд нийцсэн нэг алхам болсон юм. Тэгэхдээ энэ сургуулийн элсэлт нь манай улсын хэрэгцээнээс ахдан нүсэрдэж байгаагаас гадна дипломат алба, гадаад хэргийн магистраас доошгүй түвшний, жинхэнэ мэргэшсэн ажилтнууд бэлтгэх шаардлагыг хараахан хангаж чадахгүй байна”¹³ гэж дүгнэж байсан байна. Үнэхээр ч тухайн үед МУИС-ийн гадаад хэлний тэнхмүүдийг түшиглэн ОУХДС байгуулагдахад хичээлийн хөтөлбөрт агуулгын чанартай эрс өөрчлөлт хийхгүйгээр ОУХДС-ийн стандартын шаардлага хангасан сургалт явуулах боломжгүй байсан байгаа юм. Тэгээд ч 1999 онд МУИС-ийн удирдлага ОУХДС гэгдэх сургуулийг Гадаад хэл соёлын сургууль, Олон улсын харилцааны сургууль гэж хоёр салган хуваагаад ОУХС-д бакалаврын элсэлт авах явдлыг бүрмөсөн хааж, магистр, докторын сургалт явуулах чиглэл өгсөн байгаа юм. ОУХС-ийг ганцхан тэнхимтэй, 7 багштай, 4 туслах ажилтантай салгасан байгаа юм. 1999-2001 оны хичээлийн жилд шинэ ОУХС-ийн захирлын алба хашиж байсан Ж.Бор багш зөвхөн магистр, докторын сургалтаар олон улсын харилцааны мэргэжилтэн бэлтгэх нь учир дутагдалтай юм гэж үзэж байсан. Надад ажил өгөхдөө ч энэ тухай бас хэлж байсан. Миний бие 2001 оны 6 сард ОУХС-ийн ажил хүлээж авахдаа АНУ-ын Колумбын Их сургуульд зочин судлаачаар ажиллаж байгаад дөнгөж ирсэн болохоор МУИС-ийн ОУХС-г Колумбын Их сургуулийн ОУХС (School of International and Public Affairs)-тай харьцуулан жишихэд газар, тэнгэр хоёр шиг ялгаатай байсан. Сургуулийн орчин, сургалтын агуулга, стандарт,

¹² Элчин сайд М.Дүгэрсүрэн. Гадаад Харилцааны Яамны удирдлагад. Гадаад албаны сургалт,судалгааны сургууль байгуулах тухай санал.1994.09.19

¹³М.Дүгэрсүрэн.Гадаад хэргийн сургалт, судлалын үндэсний төвийн тухай, Төсөл, 1996, 06 сар

багшлах боловсон хүчин, бүтэц зохион байгуулалт гээд сайжруулах, шинээр хийж, байгуулах зүйл бишгүй их байсан. Энэ үед би Колумбын Их сургуулийн ОУХС-ийн багш нартай харилцаа холбоотой байсан болохоор тэднийг сургуульдаа урьж авч ирэн, байдалтай танилцуулж энэ сургуулийг цаашид яаж хөгжүүлэх тал дээр үнэтэй зөвлөмж авч, МУИС-ийн удирдлагад танилцуулж, түүгээр ч үл барам магистрын сургалтын хөтөлбөр хамтарч боловсруулж Соросын санд өгч байсан. Америкийн нэрт хятад судлаач, миний багш, Хубилай хаан номыг зохиогч профессор Моррис Россabi, мөн сургуулийн багш эдийн засагч профессор Рискин нарт сургуулийг сэргээх, хөгжүүлэхэд үнэтэй санал өгч, хамтран ажиллаж байсанд чин сэтгэлээсээ талархаж явдаг.

Дүгэрсүрэн сайдыг энэ сургуулийн төлөө зүтгэж явсан болохоор нь бас санал авах, хамтарч ажиллахаар санал болгоход дуртайяа хүлээн зөвшөөрч үнэтэй сургамжаа хайрлаж байсан байгаа юм. Энэ сургуульд шинээр тэнхмүүд байгуулах, магистр, докторын сургалт явуулах хөтөлбөрийг бүрэн дэмжиж надад хайрласан урмын үг “энэ сургууль чинь одоо л нэг зөв чигээ олох гэж байна” гэж хэлсэн нь санаанаас гардаггүй бөгөөд тухайн үедээ сургууль удирдан ажиллах итгэл надад төрүүлж байсан юм. 2001 оны 12 сард Монгол улсад Дипломат алба байгуулагдсаны 90 жилийн ойгоор ОУХС-ийн “хүндэт доктор”-т өргөмжлөх санал тавихад энэ саналыг хүлээж аваагүй, өөрөө зөвшөөрөөгүй юм. Тэгээд бид ОУХС-ийн “хүндэт өргөмжлөл” өгч, талархал илэрхийлж байсан. Хойшид сургуулийн төлөө энэ хүний хийсэн зүйлийг бид мартаx ёсгүй бөгөөд зохих журмын дагуу үнэлэх хэрэгтэй санагдана.

2002 оны өвөл ОУХС-д дахин бакалаврын анги нээх зөвшөөрөл авахаар МУИС-ийн удирдлага дээр нилээд олон хүний бүрэлдэхүүнтэй ороход Дүгэрсүрэн сайд бидний саналыг дэмжиж, магистр, докторын сургалт, судалгааны ажил явуулахыг чухалд үзэж санал болгож байсан. Ингээд 2003-2004 оны хичээлийн жилээс дахин бакалаврын анги нээх болж 2006-2007 онд шинэчилсэн хөтөлбөрөөр анхныхаа төгсөлтийг хийгээд байна.

Дүгэрсүрэн сайд манай сургуулийн үйл ажиллагаагаар гадаад албаны мэргэжилтэн бэлтгэх ажил гүйцэлдлээ гэж бодоогүй. Түүний анхнаасаа санаа тавьж байсан нэг сургалт бол дипломат ажилтнууд, гадаад харилцааны салбарт ажиллаж байгаа хүмүүсийг давтан сургах, тэдгээрийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх сургалт явуулахад санаа тавьж байсан явдал юм.

М.Дүгэрсүрэн гуай бусад оронд гадаад албаны ажилтан бэлтгэдэг туршлагатай танилцаад, ижил төрлийн сургуулиудын үүрэг зорилго, үйл ажиллагааг судалж үзээд

Гадаад харилцааны сургууль үндсэн хоёр үүрэгтэй гэж үзсэн байгаа юм. Нэгд, дипломат албаны болон гадаад харилцааны бусад талын мэргэжлийн боловсон хүчнийг сургах, давтан сургах, мэргэшүүлэх, хоёрт, дээрх салбаруудад судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг явуулах гэж үзсэн байгаа юм.

Хойшид анхаарал тавих нэг зүйл бол мэргэжилтнүүдийг давтан сургах, мэргэшүүлэх сургалт явуулах явдал юм. Энэ дээр бид ГХЯ-тай хамтран мэргэжлийн давтан сургалт явуулах шаардлагатай гэж үзэж байна. М.Дүгэрсүрэн гуай “яваандаа сургуулийн дэргэд гадаад харилцааны удирдах ажилтнуудыг бэлтгэх курс, гадаадын дипломатуудыг монгол хэл сургах, Монголын талаар мэргэжил олгох төлбөртэй сургалтыг зохион байгуулах нь зүйтэй”, хоёрдугаарт “сургуулийн дэргэд судалгааны нэгж байгуулж, түүнд эрдэм шинжилгээний хүмүүсийн зэрэгцээгээр ахмад дипломат ажилтнуудын мэдлэг мэргэжлийг ашигладаг байх нь зүйтэй”¹⁴ гэсэн хоёр чухал саналыг дэвшүүлсэн байдаг.

Манай гадаадад томилогдон ажиллах болсон дипломатуудад ажил үүргийнх нь хуваарийн дагуу түвшингөөр нь сургалт явуулах ажил огт үгүйлэгдэж байна. Бусад орны ГХЯ-ны дэргэдэх сургалтын төвүүд, Дипломат Академиуд ийм сургалтыг явуулдаг бөгөөд манай мэргэжлийн дипломатууд болон гадаадад томилогдон ажиллах болсон хүмүүсийн хүрээнд богино хугацааны дипломатын сургалт явуулах шаардлага гарч ирж байгаа юм. Энэ тухай Дүгэрсүрэн сайд бичихдээ “эцэст нь толилуулахад, янз бүрийн нэртэй гадаадын 10 шахам гадаад харилцааны институтын танилцуулга материалыг үзэхэд эдгээр нь бараг цөмөөрөө (Малайзын дипломатын ба Гадаад харилцааны Институтаас бусад нь) тухайн орны Гадаад харилцааны Яамны шууд харъяанд байдаг юм байна. Манайд ч ийм байвал зүйтэй юм шиг санагдана. Гэхдээ МУИС-ийн дэргэд “Олон улсын харилцааны дээд сургуулийн үндсийг тавьж, гадаадын ижил төрлийн сургуулиудтай харилцаа тогтоож эхэлсэн байна. ГХЯ одоодоо өөрийн дэргэд сургууль байгуулах бололцоогүй бол шав нь тавигдаад байгаа дээрх сургуулийг голлон тэтгэгч нь болох ёстой гэж бодогдоно”¹⁵ гэж ГХЯ, ОУХС хамтран ажиллах ихээхэн зөв гарц зааж өгсөн санагдана. Энэ сургалтанд ахмад туршлагатай дипломатууд, нарийн мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах нь зүйтэй юм. Энэ сургалт БСШУЯ-ны МУИС-ийн харъяаны ОУХС-ийн үүрэг гэхээсээ илүү манай ГХЯ үүнд санаа тавих цаг нэгэнт болсон гэж үзэж байна. ОУХС ГХЯ-тай хамтарч энэхүү сургалт явуулах бүрэн боломжтой юм. Бидэнд сургуулийн байр, сургалтын материал, номын сан, компьютерийн лаборатори, хэлний лингафон кабинет, багшлах

¹⁴ Мөн тэнд, тал 4

¹⁵ Мөн тэнд, тал 5

боловсон хүчин зэрэг сургалтын орчин бүгд байна. Бид Дүгэрсүрэн сайдын удаа дараа санаа тавьж, санал болгож байсан ариун гэрээсийг ОУХС, ГХЯ хамтран гүйцэлдүүлэх ёстой гэж үзэж байна. Ийм шаардлага одоо улам бүр ихсэж байгаа гэдэгтэй та бүхэн санал нэгтэй байгаа гэж бодогдоно.

Эцэст нь тэмдэглэхэд өнгөрсөн хугацаанд ОУХС-ийг дэмжиж ирсэн, хамтарч ажиллаж байсан ГХ-ны сайд асан Ц.Гомбосүрэн, Л.Эрдэнэчулуун, Дэд сайд асан А.Баттөр, Төрийн нарийн бичгийн дарга асан Б.Ганболд, ахмад дипломатч, Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд асан О.Хосбаяр, мөн манай сургуульд хичээл зааж, мэдлэг мэргэжлээ олон улсын харилцаагаар мэргэжих хүсэлтэй монголын залуучууд оюутнуудад сэтгэл харамгүй зориулж байсан ба байгаа дипломат ажилтнуудад талархал илэрхийлж байна. Хойшид ч, ГХЯ Дүгэрсүрэн сайдын санаа тавьж байсан Монголын гадаад албаны мэргэжилтэн, дипломатуудад зориулсан, ахисан шатны түвшинд бэлтгэх, давтан сургах үйлст санаа тавьж ОУХС-тай хамтарч ажиллавал бид бэлэн байна.